



ШИНЖЛЭХ УХААН  
ТЕХНОЛОГИЙН САНГИЙН ЗАХИРЛЫН  
ТУШААЛ

2022 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/111

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 108 дугаар зүйлийн 108.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 50 дугаар тогтоолоор батлагдсан Шинжлэх ухаан, технологийн сангийн дүрмийн 2.4.3, 2.4.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. “Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж ур чадварын нэмэгдэл олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа хяналт шинжилгээний хэлтэс /Э.Бат-эрдэнэ/-т, журмыг хэрэгжүүлэхэд холбогдон гарах зардлыг Санхүү төлөвлөлтийн хэлтэс /Б.Отгонжаргал/-т тус тус даалгасугай.
3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Шинжлэх ухаан, технологийн сангийн захирлын 2020 оны 01 сарын 06-ны өдрийн “Журам батлах тухай” А/01 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ЗАХИРАЛ



Д.ОДГЭРЭЛ



Шинжлэх ухаан технологийн сангийн  
захирлын ...2022...оны ...04...сарын...08...өдрийн  
...11...дугаар тушаалын хавсралт



## АЖИЛТНЫ АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ҮНЭЛЖ УР ЧАДВАРЫН

### НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

#### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар "Шинжлэх ухаан, технологийн сан" -гийн /цаашид "ШУТСан" гэх/ ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэх, ур чадварын нэмэгдэл олгох харилцааг зохицуулна.

1.2. Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ нотолгоонд суурилсан, шударга, бодитой, ил тод, нээлттэй байх зарчмыг баримтална.

1.3. Энэхүү журмын зорилго нь ажилтан, албан тушаалын тодорхойлолтод заасан ажил үүрэг болон жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөгөө хэрхэн биелүүлж байгааг ажлын үр дүн, гүйцэтгэлийн чанар, мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагын хувьд үнэлж, дүгнэх, алдаа дутагдлыг залруулах болон ажилтны идэвх санаачлагыг нэмэгдүүлэх, зохих үр дүнг урамшуулахад оршино.

1.4. ШУТСангийн ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлэхдээ Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, ШУТСангийн дүрэм, Хөдөлмөрийн дотоод журам болон энэхүү журмыг мөрдөнө.

#### Хоёр. Ажлын гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт,

#### ажлын гүйцэтгэлийг үнэлэх

2.1. ШУТСангийн ажилтны ажлын гүйцэтгэлийг дараах үндсэн үзүүлэлтээр үнэлнэ.

№	Шалгуур үзүүлэлт	Эзлэх хувь
1	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний биелэлт болон нэмэлт /төлөвлөгөөт бус/ ажлын гүйцэтгэл	70%
2	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ, багаар ажиллах чадвар	25%
3	Мэдлэг чадвар түүнийг дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	5%
Нийт		100%



- 2.2. Ажилтны ажлын гүйцэтгэлийг дараах албан тушаалтан үнэлнэ. Үүнд:
- 2.2.1. Хэлтсийн албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг хэлтсийн дарга;
  - 2.2.2. Хэлтсийн даргын ажлын гүйцэтгэлийг ШУТСангийн захирал.
- 2.3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ, багаар ажиллах чадварын үнэлгээг байгууллагын ажилчдаас хоёрдугаар хавсралтад заасан хүснэгтийн дагуу санал авна.

### **Гурав. Гүйцэтгэлийн үнэлгээ хийх аргачлал**

3.1. ШУТСангийн ажилтныг ажлын гүйцэтгэлийн үнэлгээнээс хамаарч дараах байдлаар ур чадварын нэмэгдэл бодно. Үүнд:

<b>Үнэлгээний ангилал</b>	<b>Ажлын гүйцэтгэлийн үнэлгээ</b>	<b>Ур чадварын нэмэгдэл</b>
Маш сайн	95-100	25%
Хангалтай сайн	90-95	20%
Сайн	85-89	15%
Дунд	70-85	10%
Сайжруулах шаардлагатай	69 ба түүнээс доош	0%

3.2. Тухайн сарын ур чадварын нэмэгдлийг өмнөх сарын гүйцэтгэлийн үнэлгээгээр олгоно. Ур чадварын гүйцэтгэлийг сар бүрийн 25-ны өдөр хэлтсийн дарга нар 2.1 дэх шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээ хийж, захиралд танилцуулна.

3.3. Туршилтын хугацаагаар ажиллаж байгаа болон сахилгын арга хэмжээ авагдсан, жилийн ажлын цагийн сан нь 70 хувьд хүрээгүй тохиолдолд ур чадвар олгохгүй.

3.4. Ажилтны эмнэлгийн магадалгаагаар өвчтэй болон чөлөөтэй байсан өдрүүдэд ур чадварын нэмэгдэл бодогдохгүй.

3.5. Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журмыг үндэслэн нарийн бичиг, нярав үйлчлэгчийн ур чадварыг үнэлэх.

3.6. Ур чадварын нэмэгдлийг олгох эсэх асуудлыг байгууллагын санхүүгийн чадавх, цалингийн сангаас хамааруулан хэлтсийн дарга нарын үнэлгээг үндэслэн Захирал тушаал гаргана.



Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж ур чадварын  
нэмэгдэл олгох журмын нэгдүгээр хавсралт

Ур чадварын үнэлгээ тооцсон хүснэгт

Хэлтэс:.....

№	Нэр	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилт, арга хэмжээний биелэлт болон нэмэлт /төлөвлөгөөт бус/ ажлын гүйцэтгэл	Мэдлэг чадвар, түүнийг дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ, багаар ажиллах чадвар	Нийт оноо	Ур чадварын нэмэгдлийн хувь
		70	5	25		
1						
2						
3						
4						
5						
6						
7						

Үнэлгээ:

95-100 оноо 25%,  
90-95 оноо 20%,  
85-89 оноо 15%,  
70-85 оноо 10%,  
69 доош 0%.

Үнэлгээ гаргасан:

.....

—oOo—



Ажилтны ажлын гүйцэтгэлийг үнэлж ур чадварын  
нэмэгдэл олгох журмын хоёрдугаар хавсралт

**Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ, багаар ажиллах чадварын  
үнэлгээ тооцсон хүснэгт**

№	Овог нэр	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ, багаар ажиллах чадвар /25 хүртэл/
1		
2		
3		
..		
..		
23		
24		

---oOo---